



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 34  
дүгээр сургуулийн данс бүртгэлд  
хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 5 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Уншигч" төрийн бус байгууллагаас хандивласан нийт 13,000,000.00 (арван гурван сая) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 34 дүгээр сургууль (Р.Өлзийхишиг)-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 34 дүгээр сургууль (Р.Өлзийхишиг)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500693

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын  
2024 оны ..... дугаар сарын ..... өдрийн  
..... дугаар тушаалын хавсралт

Хөрөнгө бүртгэх тухай

Байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын 34-р сургууль

| №                          | Эд хөрөнгийн нэр          | Ашиглалтад авсан он | Чанар байдал | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Бүртгэх анхны |               | Хандивлагч, байгууллага |                        |
|----------------------------|---------------------------|---------------------|--------------|-------------|------------|---------------|---------------|-------------------------|------------------------|
|                            |                           |                     |              |             |            | Нэгжийн үнэ   | Нийт үнэ      | Нэр                     | Эх үүсвэр              |
| 1                          | Уншлагын ном /1-5-р анги/ | 2024.01.02          | сайн         | ш           | 750        |               | 11,250,000.00 |                         | "Уншигч" ТББ<br>Хандив |
| 2                          | Номын тавиур /дугуйтай/   | 2024.01.02          | сайн         | ш           | 5          | 350,000.00    | 1,750,000.00  |                         |                        |
| Нийт бүртгэх хөрөнгийн дүн |                           |                     |              |             |            |               | 13,000,000.00 |                         |                        |